



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 9/102

Улаанбаатар хот

Цахим төхөөрөмжийн өрөө, түүнийг
ашиглах журмыг батлах тухай

Монгол Улсын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1.5, 22.1.1, 22.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" 141 дүгээр тогтоолын 2.1, 2.2, 2.3, Нийслэлийн Засаг даргын 2013 оны "Мэдээллийн аюулгүй байдлын хангаж ажиллах журам батлах тухай" А/144 дүгээр захирамж, Онцгой байдлын өрөнхий газрын даргын 2015 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын албаны цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ын 1.2, 1.3, 1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтэцийн нэгжийн Цахим төхөөрөмжийг хадгалах, хамгаалах өрөө, ашиглах журмыг хавсралтаар баталсугай.
2. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтэцийн нэгжийн Цахим төхөөрөмжийг, ашиглах журмыг үйл ажиллагаандaa мөрдөж, хяналт тавьж ажиллахыг тус газрын компьютер программ хангамж, кибер аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтан, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, харьяа анги салбарын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЧҮЛТЭМСҮРЭН





Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 09 дугаар сарын 23 -ны өдрийн
23 дугаар тушаалын хавсралт

ЦАХИМ ТӨХӨӨРӨМЖ /СЕРВЕР/-ИЙН ӨРӨӨ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Онцгой байдлын газрын цахим төхөөрөмжүүдийг байрлуулах, өрөө, тасалгаа, түүнд тавигдах шаардлага, түүнийг зүй зохистой ашиглах, хэвийн үйл ажиллагааг энэхүү журмаар хангана.

1.2. Нийслэлийн Онцгой байдлын газрын цахим тооцоолуур /сервер/ компьютер, сүлжээний үндсэн төхөөрөмж нэг бүрийг эрх бүхий мэдээллийн технологийн мэргэжилтэн /цаашид "мэргэжилтэн" гэх/ хариуцаж мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй.

Хоёр. Цахим төхөөрөмж / сервер/-ийн өрөөнд тавигдах шаардлага

2.1. Өрөө нь нарны гэрэл шууд тусахгүй, ус чийггүй, халуун хүйтний хэлбэлзэл бага, хүчтэй соронзон орноос хол, тоосорхог бус орчинд сонгоно.

2.2. Өрөө нь хөргөлтийн төхөөрөмж, кабель тараагч сувагчлал, цахилгаан тэжээлийн самбартай байна. Эдгээр зүйл нь бүгд техникийн нөхцөл стандарт дүрмийн дагуу шийдвэрлэгдсэн байна.

2.3. Өрөөнд зогсууруудыг нэгэн шугаманд эгнээ эгнээгээр жигд байрлуулна. Зогсуур бүр дугаартай байна.

2.4. Өрөөний зогсуурт сервер компьютер, рутор, свич, кабел, тэжээлийн залгуур болон бусад шаардлагатай төхөөрөмжийг тавиур дээр байрлуулах шаардлагатай. Тавиур тус бүрийг дугаарласан байна. Мөн тавиур дээрх тоног төхөөрөмжийн эд анги тус бүрийг дугаарласан байна.

2.5. Өрөө нь галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байна. Мөн хөдөлмөрийн болон техникийн нөхцөл дүрмийн дагуу бүрэн гэрэлтүүлэгтэй байна.

2.6. Өрөө нь стандартын дагуу галын болон аваарын дохиолол, хяналтын камер, чийгшүүлэгч төхөөрөмжэй байна.

2.7. Өрөөнд агааржуулалт, халаалтыг мэдрэх тоног төхөөрөмжийг суурилуулна. Эдгээр тоног төхөөрөмж нь 24 цагийн турш тогтмол ажиллагаатай байна.

2.8. Өрөөн дэх системүүдийн кабель шугамын (дотоод сүлжээ, E1, UTP кабелийн холболт г.м) холболтыг нягт нямбай хийнэ. Бүх кабель шошготой байна.

2.9. Кабелиудыг татаж байрлуулахдаа тухайн тоног төхөөрөмжтэй ажиллахад саад болохооргүй эмх цэгцтэй татна.

2.10. Цахилгаан зайд тэжээл хариуцсан инженерээр серверийн өрөөн дэх тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүчний нийт зарцуулалтыг тооцоолуулсан байна.

2.11. Өрөөнд шаардлагатай цахилгаан эрчим хүчний хэмжээг (чадал) цахилгааны автомат хайрцаг дээр бичнэ

Гурав. Цахим төхөөрөмжийн /сервер/-ийн өрөөнд нэвтрэх

3.1. Өрөө, тасалгаанд тус газрын удирдлага, хариуцсан мэргэжилтэн, тусгай зөвшөөрөл бүхий албан тушаалтан нэвтрэнэ.

3.2. Өрөөг эзэнгүй үед хаалгыг нь байнга түгжинэ. Түлхүүрийг мэргэжилтэн хадгална. Өрөөний хаалга хурууны, хээ кодоор онгойдог байж болно.

Дөрөв. Цахим төхөөрөмж / сервер / -ийн байх анхааруулах тэмдэгнүүд

4.1. Өрөөн дэх мэдээллийн самбар дээр дараах мэдээллийг байрлуулна.

4.1.1. Өрөөнд идэж, уухыг хориглосон тэмдэг

4.1.2. Өрөөнд зөвшөөрөлгүй орохыг хориглосон тэмдэг;

4.1.3. Чухал шаардлагатай утасны дугаарууд;

4.1.4. Мэдээллийн технологийн мэргэжилтний утасны дугаар;

4.1.5. Онцгой тусламжийн үйлчилгээний утасны дугаар

Тав. Цахим төхөөрөмжийн сервер-ийн өрөөнд дараах зүйлүүдийг хориглоно

5.1. Тамхи татах;

5.2. Зориулалтын бус тоног төхөөрөмж болон эд хогшил байлгах;

5.3. Гадны хүн зөвшөөрөлгүй нэвтрэх;

5.4. Шатамхай буюу тэсрэх дэлбэрэх зүйл оруулах;

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас цахим тооцоолуур болон сүлжээний үндсэн төхөөрөмжийн үйл ажиллагаанд ямар нэгэн гэмтэл saat ал гаргасан, хохирол учруулсан, цахим төхөөрөмж /сервер/-ийн өрөөний журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.